



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 4 сарын 22 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр бүлгийн 1.4, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэгдэн батлагдсан журмыг биржийн ажилтан, харилцагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэлтсийн менежер нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсан холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Р.Ариунбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.НАРАНДЭЛГЭР

Гүйцэтгэх захирлын 2022 оны
...4... дүгээр сарын 22...-ны
өдрийн 43 дүгээр тушаалын
хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

1 ДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-ийн өдөр тутмын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд болон дотоод үйл ажиллагаанд хяналт тавьж, хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээдийн эрх, үүрэг, хянан шалгах харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журамд заасан чиг үүргийг хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд гүйцэтгэх ба хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд энэхүү хяналт шалгалт нь хараат бус, шударга, хяналт шалгалт хэрэгжүүлэх этгээдийн үйл ажиллагаа бодитой, нээлттэй байх, компанийг аливаа эрсдэлд оруулахгүй байх зарчмыг баримтлана.

1.3 Журмаар нарийвчлан зохицуулаагүй харилцааг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж бусад актад зааснаар зохицуулна.

1.4 Хяналтын журам болон бусад журмын хоорондын уялдааг хангах зарчмыг баримтлана. Үүнд:

1.4.1. Хөдөлмөрийн дотоод журам;

1.4.2. Ес зүйн дүрэм;

1.4.3 Биржийн үйл ажиллагааны журам болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам,

1.4.4. Аливаа төрлийн гэрээ, хэлцэл.

1.5 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёо, ойлголтыг Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон бусад журамд зааснаар тайлбарлана.

1.5.1. “Арилжааны жишиг үнэ” гэж Арилжаанд оролцогч биржийн гишүүний захиалгын үнийг хэт савлахаас сэргийлэх зорилгоор оруулах үнэ;

1.5.2. “Үнийн манипуляци” гэж Санаатайгаар биржийн үнэд нөлөөлөх эсвэл нөлөөлөхийг оролдох буюу дараах үйл ажиллагааг ойлгоно.

✓ Санаатайгаар үнэд нөлөөлөх эсвэл нөлөөлөхийг оролдсон;

✓ Биржийн арилжаанд зохиомол үнэ оруулсан;

✓ Санаатайгаар хуурамч эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл цацсан;

✓ Зах зээлийн үнэ тогтох механизмд нөлөөлөх зорилго бүхий хуйвалдааны захиалга оруулсан;

✓ Биржээс тогтоосон бүх төрлийн хязгаарт санаатайгаар нөлөөлсөн.

1.5.3. “Арилжааг автоматаар зогсоох” гэж Арилжааны үед барааны үнийн хэвийн бус өөрчлөлт илэрсэн үед арилжааг урьдчилан тодорхойлсон хугацаанд түр зогсоох;

1.5.4. **“Итгэмжлэгдсэн этгээд”** гэж Биржийн итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж, биржтэй гэрээ байгуулсан агуулах, тээврийн байгууллага, лаборатори;

1.5.5. **“Төлбөр тооцоо гүйцэтгэгч банк”** гэж Биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй арилжааны банк;

1.5.6. **“Бусад харилцагч байгууллага”** гэж Биржтэй хамтран ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага;

1.5.7. **Хуурамч арилжаа (захиалга):** Арилжаанд оролцогчийн оруулсан захиалга нь зах зээлд хуурамч дохио өгч бүтээгдэхүүний үнэ болон авах, зарах хэмжээнд нөлөөлөх эсвэл нөлөөлөхийг оролдох буюу дараах үйл ажиллагааг ойлгоно.

✓ Биржээр арилжих барааны эзэмшигчийн хувьд өөрчлөлт оруулахгүйгээр 2 тал урьдчилан тохиролцон арилжаанд оролцох;

✓ Арилжаанд оролцогч олон нийтэд зах зээлийн үнэ болон эрэлтийн талаар сэтгэгдэл төрүүлэх зорилгоор захиалга оруулах;

✓ Хоорондоо биелэхээр ижилхэн үнэ бүхий авах, зарах захиалга зэрэг оруулах эсвэл ойролцоо хугацаанд оруулах;

1.5.8. **“Хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд”** гэж Биржийн Гүйцэтгэх захирал, чиг үүрэг хариуцсан хэлтсийн менежерийн шууд удирдлагад байх бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад этгээдээс хараат бус, хяналт шалгалтын чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

2 ДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ

2.1. Хяналт, шалгалт гэж арилжаа, клиринг, төлбөр тооцоо, биржээр арилжих бараа, түүхий эдийн хадгалалт, хүргэлтэд тавих хяналт, биржийн гишүүн, итгэмжлэгдсэн этгээд, биржийн хооронд үүсэх харилцаанд болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг хэлнэ.

2.2. Хяналт, шалгалт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

Үйл ажиллагааны хяналт

2.2.1. Арилжааны үйл ажиллагаа;

2.2.2. Клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаа;

2.2.3. Гишүүнчлэлийн эрх, итгэмжлэл олгох үйл ажиллагаа;

2.2.4. Биржийн үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах асуудал.

Нийцлийн хяналт

2.2.5. Нийцлийн хяналт гэж удирдах дээд байгууллагаас гаргасан хууль тогтоомж, дүрэм журам, тусгай горим байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн мөрдөгдөж байгааг шалгаж тогтоодог хяналтын хараат бус хэлбэр юм. Биржийн дотоод үйл ажиллагааны нийцлийн хяналтад дараах үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

2.2.5.1. Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн нийцлийн хяналт

2.2.5.2. Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын гаргасан тушаал, шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.5.3. Биржийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын хоорондын уялдаа холбоо хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих;

2.2.5.4. Биржийн үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.5.5. Биржтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.5.6. Компанийн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих.

Гүйцэтгэлийн хяналт

2.2.6. Хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны төлөвөлгөө, тайлан, гүйцэтгэлд хяналт тавих;

2.2.7. Хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх;

2.2.8. Ажилтны ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх.

Хяналт шалгалтын арга хэлбэр

2.3. Хяналт, шалгалтыг дараах арга хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1. Өдөр тутмын буюу байнгын;

2.3.2. Төлөвлөгөөт;

2.3.3. Төлөвлөгөөт бус;

2.3.4. Гүйцэтгэлийн.

2.4. “Өдөр тутмын буюу байнгын” гэж биржийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллахыг ойлгоно.

2.5. “Төлөвлөгөөт хяналт шалгалт” гэж хяналт, шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь биржийн тухайн оны эрсдэлийн үнэлгээг харгалзан 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хяналт шалгалтын хийх төлөвлөгөөг хараат бус зарчмыг баримтлан Гүйцэтгэх захирлаар баталгаажуулан, удирдамж боловсруулан ажиллахыг ойлгоно.

2.6. “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт” гэж эрсдэл үүссэн, үүсэх нөхцөл байдал бий болсон, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, харилцагчаас ирүүлсэн мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, аливаа гэнэтийн нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэх захирлаар удирдамжаа баталгаажуулан, хууль тогтоомж болон бусад заасан үндэслэлээр хийж гүйцэтгэхийг ойлгоно. Энэхүү хяналт шалгалтыг гагцхүү түүнийг явуулах болсон үндэслэл, удирдамжид заасан асуудлын хүрээнд хийнэ.

2.7. “Гүйцэтгэлийн шалгалт” гэж өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийж гүйцэтгэхийг ойлгоно.

2.8. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжид дараах зүйлсийг тусгана. Үүнд:

2.8.1. Он, сар, өдөр, удирдамжийн дугаар;

2.8.2. Шалгалтын зорилго, үндэслэл;

2.8.3. Шалгалтын төрөл, арга, хэлбэр;

2.8.4. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах этгээд, объектын нэр;

2.8.5. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;

2.8.6. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа;

2.8.7. Өмнө хийсэн шалгалтын талаархи мэдээлэл.

2.9. Хяналт шалгалт эхлэхээс өмнө шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, удирдамжийг танилцуулсан байвал зохино.

2.10. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд хоёр хувь тэмдэглэл үйлдэх бөгөөд нэг хувийг шалгуулагч этгээдэд өгч, шалгалтын тэмдэглэлд дараах үндсэн мэдээллийг тусгана. Үүнд:

2.10.1. Шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал;

2.10.2. Санал, дүгнэлт;

2.10.3. Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт.

2.11. Шалгуулагч этгээд тэмдэглэлтэй танилцан гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд татгалзсан тохиолдолд энэ тухайгаа тэмдэглэлд тусгана.

2.12. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь шалгалтын тэмдэглэлийг Гүйцэтгэх захиралд шалгалт дууссанаас хойш 3 хоногийн дотор танилцуулах бөгөөд зөрчил илэрсэн тохиолдолд шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, түүний нотлох баримт, танилцуулгыг тэмдэглэлд хавсаргаж буруутай этгээдэд хариуцлага ногдуулах талаар саналаа хүргүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллана.

2.13. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн шинжийг агуулж байвал хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

3 ДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээдийн дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Үүнд:

3.1.1. Арилжаанд оролцогч арилжааны брокерын эрхийн үнэмлэхтэй, Биржээс тавигдах шаардлагуудыг хангаж байгаа эсэх;

3.1.2. Арилжаанд оролцогч нь арилжаанд Биржээс олгосон тусгай дугаарын дагуу оролцож байгаа эсэх;

3.1.3. Арилжаанд оролцогч өөрийн болон харилцагчийнхаа нэрийн өмнөөс, өөрийн эсвэл харилцагчийнхаа дансыг ашиглан арилжаанд оролцож байгаа эсэх;

3.1.4. Арилжаанд оролцогчийн захиалгын дагуу захиалга цахим горимд хийгдэж байгаа эсэх, арилжаанд оролцогч нь цахим арилжааны системд бараа авах, зарах захиалга оруулах, оруулсан болон биелээгүй захиалгаа цуцлах, захиалгын нөхцөлийг өөрчлөхтэй холбоотой системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийж байгаа эсэх;

3.1.5. Арилжааны үеэр арилжааны систем, Биржийн дотоод сүлжээг зүй бусаар ашигласан эсэх, бусад оролцогчийг үл хүндэтгэж, ёс зүйн алдаа дутагдал гаргасан эсэх;

3.1.6. Арилжаанд оролцогч дангаараа, эсвэл хэсэг бүлгээрээ нийлэн бусад арилжаанд оролцогчийн барааны чанар, стандартын талаар буруу мэдээлэл цацах, эсвэл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц үнэ, тоо ширхэг, шинж чанартай холбоотой буруу ташаа мэдээлэл санаатайгаар тарааж, бусад оролцогчийг төөрөгдүүлэх, улмаар зах зээл дээр үнэ тогтох явцад сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан эсэх;

3.1.7. Биржийн ажилтан, биржийн арилжаанд оролцогч нь дотоод мэдээ, мэдээлэл ашиглах буюу бусдад дамжуулах замаар арилжааны үеэр аль

нэгэн арилжаанд оролцогч, эсвэл хэсэг бүлэг этгээдэд давуу тал олгох оролдлого хийсэн эсэх;

3.1.8. Арилжаанд оролцогчийн оруулсан захиалга, хийсэн хэлцэл нь Биржийн арилжааны зах зээлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бий болгосон эсэх;

3.1.9. Биржийн гишүүн харилцагчийн авах, зарах захиалгыг санаатайгаар дарагдуулсан, дарагдуулах замаар Биржийн барааны үнэ ханшийг өсгөсөн, унагаасан, эсвэл ийм төрлийн оролдлого хийсэн эсэх;

3.1.10. Арилжаанд оролцогч бусад оролцогчийн хувьд Биржийн барааг худалдахгүй, худалдан авахгүй, захиалахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үнэ ханшийг тодорхой түвшинд барих оролдлого хийсэн, эсвэл тодорхой түвшинд барьсан эсэх;

3.1.11. Хаагдах хугацаа нь ойртож буй гэрээний оролцогч талууд гэрээний үүргийн биелэлт, гэрээний төлбөр тооцоо болон хүргэлтийг журмын дагуу хийгдэж буй эсэх;

3.1.12. Арилжаа зохион байгуулах этгээд болон арилжаа хянагч нь арилжааны явцад зах зээлийн хэвийн бус нөхцөл байдал үүссэн, гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл, гал түймэр, үймээн самуун, бослого, Биржээс хамаарахгүй техникийн саатал зэрэг үүссэн тохиолдолд арилжаа эхлэх, хаах цагийг өөрчлөх, позици, үнэ, баталгаат дэнчингийн хязгаар өөрчлөх болон бусад шаардлагатай эрсдэлийг удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх;

3.1.13. Арилжааны манипуляцийг үүсгэсэн эсэх;

3.1.14. Хуурамч арилжаа (захиалга): Арилжаанд оролцогчийн оруулсан захиалга нь зах зээлд хуурамч дохио өгч бүтээгдэхүүний үнэ болон авах, зарах хэмжээнд нөлөөлөх эсвэл нөлөөлөхийг оролцдсон эсэх;

3.1.15. Арилжааны үнэ болон бусад арилжаанд оролцогчийн захиалгад нөлөөлөх захиалгыг оруулан биелэхээс нь өмнө устгасан тохиолдол давтагдсан эсэхэд хяналт тавина. Үүнд дараах үйл ажиллагааг хамруулан ойлгоно.

а. Арилжааны үр дүнд нөлөөлөх дотоод мэдээлэл ашиглан захиалга оруулсан;

б. Маш их хэмжээний хэлцэл зөвхөн ганцхан арилжаанд оролцогчтой хийгдсэн бол;

в. Арилжааны системд автоматаар маш богино хугацаанд захиалга оруулах мэдээллийн технологи ашигласан нь зах зээлийн хэвийн нөхцөл, үнийн тогтвортой байдлыг алдагдуулсан бол;

г. Биржийн дэнчин, барьцаа, төлбөр тооцоо болон бараа хүргэлт, агуулахын үйл ажиллагаатай холбоотой журмуудыг зөрчсөн.

3.2. Арилжааны хэвийн бус үйл ажиллагаа илэрсэн тохиолдолд арилжааны хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь ноцтой биш гэж үзвэл сануулах, бичгээр тайлбар авах, нэмэлт мэдээлэл авах, шинэ позици нээх эрхийг түр хугацаанд цуцлах, тодорхой хугацаанд нээлттэй позицийг хаах тухай мэдэгдэх, шаардсан хугацаанд позици хаагагүй тохиолдолд хүчээр хаах зэрэг арга хэмжээ авна.

3.3. Арилжааны хяналтыг хэрэгжүүлэхдээ дэнчингийн хязгаар, үнийн хязгаар, позицййн хязгаар, том дүнтэй арилжааны хяналт, хүчээр позици хаах зэрэг эрсдэлийн удирдлагын аргуудыг ашиглана.

3.4. Фьючерс гэрээ болон спот арилжааны барааны үнийн хэвийн бус өөрчлөлт илэрсэн үед арилжааг тодорхой хугацаанд зогсоох түр зогсоох арга хэмжээ авна. Хэрвээ арилжааны үед тогтож буй үнэ өмнөх өдрийн хаалтын үнээс 10-аас их хувиар өөрчлөгдвөл арилжааг 20 минутын хугацаанд түр зогсоож дахин эхлүүлэх бөгөөд өмнөх өдрийн хаалтын үнээс 20-оос их хувиар өөрчлөгдвөл тухайн өдрийн арилжааг зогсооно.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ. КЛИРИНГ, ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Клиринг, төлбөр тооцооны дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Үүнд:

4.1. Биржийн гишүүн нь арилжаанд оролцох, арилжааны дараах клиринг, төлбөр тооцооны гүйцэтгэлтэй холбогдон гарсан аливаа санхүүгийн үүргээ биелүүлсэн эсэх;

4.2. Клиринг, төлбөр тооцоо хариуцсан хэлтэс өдөр тутмын болон төлбөр тооцоо, эцсийн төлбөр тооцоог гүйцэтгэх хугацаанд худалдан авагч тал гэрээний үнийн дүнг төлбөр тооцооны дансанд шилжүүлээгүй тохиолдолд бирж болон гэрээний нөгөө талд төлбөл зохих аливаа мөнгөн дүнг заасан хугацаанд төлсөн эсэх;

4.3. Биржид төлбөл зохих, төлөхийг шаардсан бусад төлбөр (арилжааны шимтгэл, клиринг, төлбөр тооцооны шимтгэл, гишүүний хураамж гэх мэт) төлөгдсөн эсэх;

4.4. Клирингийн эрхтэй гишүүн нь барьцаа хөрөнгийг заасан хугацаанд байршуулаагүй мөн байнгын гишүүн баталгаат дэнчин, өөрийн харилцагчийн анхдагч дэнчинг заасан хугацаанд байршуулсан эсэх;

4.5. Хүргэлттэй гэрээний хувьд барааг хүргэх, хүлээн авах үүргээ биелүүлсэн эсэх;

4.6. Биржийн гишүүн нь гэрээний үүргээ биелүүлсэн, эсвэл зөрчил гаргасан эсэх.

5 ДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮНЧЛЭЛ, ИТГЭМЖЛЭЛИЙН ЭРХ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гишүүнчлэл, итгэмжлэлтэй холбоотой дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Үүнд:

5.1. Биржийн гишүүн, итгэмжлэгдсэн этгээд нь Биржийн холбогдох хууль, дүрэм журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсэх;

5.2. Биржийн гишүүний шалгуур үзүүлэлт хангаж байгаа эсэх;

5.3. Биржийн гишүүнтэй байгуулсан гэрээнд хориглосон үйл ажиллагаа явуулсан эсэх

5.4. Бирж нь хүсэлт гаргагчийн баримт бичиг үнэн зөв эсэх;

5.5. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх;

5.6. Биржийн гишүүний эрх, үүргээ биелүүлж чадах чадвар чадамжтай эсэх.

6 ДУГААР БҮЛЭГ. ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ, АРИЛЖААНЫ ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Цахим хөгжүүлэлт, арилжааны хяналттай холбоотой дараах үйл ажиллагаанд тавьж ажиллана. Үүнд:

6.1.1. Биржийн цахим системийн хамрах хүрээнд компанийн үйл ажиллагаанд тухайн системийг ашиглах боломжоор хангах, засвар үйлчилгээнд тогтмол, шуурхай арга хэмжээ авч ажиллах, хэвийн тасралтгүй явуулах боломжоор хангасан эсэх;

6.1.2. Үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэх;

6.1.3. “Айтүүлс” ХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлт зохих ёсоор гүйцэтгэж байгаа эсэх;

6.1.4. Биржийн цахим систем хэвийн горимоор ажилласан эсэх, доголдол үүссэн бол доголдлыг засах арга хэмжээг авч ажилласан эсэх;

6.1.5. Биржийн цахим системийн хэвийн ажиллагаа, мэдээллийн нууцлал алдагдах, аливаа кибер халдлагад өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажилласан эсэх.

6.1.6. 6.2-т заасан журмын дагуу үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэж байгаа эсэх.

6.2. Биржийн цахим систем мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулна.

7 ДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд дараах эрхийг эдлэнэ. Үүнд:

7.1. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа хяналт, шалгалтыг төрөл, арга хэлбэрийг сонгон ашиглах, удирдамжийг батлуулах;

7.2. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэх

7.3. Хяналт, шалгалтын үйл ажиллагааны явцад шалгагдаж буй хэлтэс, ажилтнаас шалгалттай холбогдолтой санхүүгийн болон бусад баримт, эрхийн актыг шаардаж авах буюу ярилцлага хийж тайлбар гаргуулах;

7.4. Хяналт шалгалт явуулахдаа хэлтсийн удирдлага, ажилтантай шууд харилцагч тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулах;

7.5. Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь Биржийн бүх ажлын байранд хориг саадгүй нэвтэрч хяналт шалгалтын ажилд шаардагдах аливаа баримт мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан авах;

7.6. Хяналтын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагааг Гүйцэтгэх захиралд тогтмол тайлагнах, баталгаажуулж, холбогдох саналаа компанийн Гүйцэтгэх захиралд тавих;

7.7. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар зөрчил гаргасан ажилтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг компанийн Гүйцэтгэх захиралд танилцуулах;

7.8. Биржийн ажилтан холбогдох журмыг зөрчиж, байгууллага болон харилцагчид тодорхой хэмжээний хохирол буюу учруулсан нь хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шаардлагагүй тохиолдолд Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд энэхүү журмын 1.4-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх тухай асуудлаар санал боловсруулан Гүйцэтгэх захиралд танилцуулах;

7.9. Шалгалтаар илэрсэн зөрчил нь бусдад хохирол учруулсан бол хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тооцож захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэх;

Хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд дараах үүргийг хүлээнэ.Үүнд:

7.10. Биржийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, зөрчил дутагдлыг илрүүлэн арилгахтай холбогдуулан бүх шатны ажилтнуудад зөвлөмж, зааварчилгааг тухай бүрт нь өгч ажиллах;

7.11. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг тухай бүр хэлтэс хариуцсан удирдлагад мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авах;

7.12. Хяналт шалгалтаар залилан, сэжигтэй гүйлгээ, гэмт хэргийн шинжийг агуулсан үйл явдал, баримт илэрсэн бол Гүйцэтгэх захиралд энэ талаар тухай бүр мэдээлэл өгөх;

7.13. Биржийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг Гүйцэтгэх захиралд мэдэгдэх;

7.14. Хяналт шалгалт, өөрийн гүйцэтгэсэн үүрэгтэй холбоотой байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг задруулахгүй байх;

7.15. Шалгалтын эцсийн дүгнэлт, бичсэн тайлан, зааварчилгаа, сэрэмжлүүлэг, ажлын баримт, нотолгооныхоо үнэн зөвийг бүрэн хариуцах;

7.16. Холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

7.17. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

7.18. Хяналт шалгалтын талаар бүртгэл хөтлөх, мэдээллийн сан үүсгэх.

8 ДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН, ХОРИГЛОХ ЗҮЙЛ, ХАРИУЦЛАГА

Хяналт шалгалтын тайлан, мэдээ

8.1. Хяналт шалгалтын тайланд холбогдох нотлох баримт, тайлбар зэрэг шаардлагатай баримт материалыг хавсаргана.

8.2. Тайланд шалгалтаар илэрсэн зөрчлийн шалтгааныг үр дагавартай нь цогц байдлаар тодорхой бичиж, зөрчлийг хэрхэн арилгах санал, зөвлөмжийг тусгасан байна.

8.3. Хяналт шалгалтын дүнг бичгээр гаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Гүйцэтгэх захиралд зөрчлийн мэдээллийг аман хэлбэрээр өгч болно.

Хяналт шалгалтад хориглох зүйл

8.4. Үүрэгт ажлаа гүйцэтгэх явцдаа илрүүлсэн зөрчил, дутагдал, холбогдох баримт мэдээллийг нуун дарагдуулах, бусдын нөлөөнд автах;

8.4.1. Хяналт шалгалтын дүн, мэдээллийг Гүйцэтгэх захирал, хэлтэс хариуцсан удирдлагад танилцуулаагүй, зохих шийдвэр гараагүй байхад зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээллэх, тараах;

8.4.2. Хяналтад хамаарахгүй асуудлаар бусдын ажилд оролцох, саад учруулах;

8.4.3. Хяналт шалгалтын дүнг санаатайгаар гуйвуулах, батлагдаагүй, үндэслэлгүй нотлох баримтгүй асуудлыг шалгалтын дүн тайланд тусгах;

8.4.4. Хяналт шалгалтыг явуулахдаа бусдын нэр хүндэд халдах, гүтгэх, доромжлох, айлган сүрдүүлэх зэргээр ёс бус үйлдэл гаргах, ёс зүйн зөрчил гаргах;

8.4.5. Шалгалтанд хувийн сонирхолоор хандах, шалгуулж буй ажилтнаас ажил үүргийн хуваарьт хамаарахгүй баримт материал шаардах.

8.5. Энэхүү журмын дагуу эрх, үүргийг хэрэгжүүлж буй хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдэд бусад хэлтэс, удирдах албан тушаалтнаас аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Хариуцлага

8.6. Гишүүнчлэл, төлбөр тооцоо, арилжааны үйл ажиллагаатай холбоотой зөрчилд дараах арга хэмжээг авч ажиллах ба үүгээр зохицуулагдаагүй харилцааг 8.13-8.20-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ: Үүнд:

8.6.1. Хэрэв биржийн гишүүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй, биржид болон түүний гишүүн аль нэг харилцагчид төлбөл зохих мөнгөн дүнг цаг хугацаанд нь төлөөгүй зэрэг санхүүгийн үүргээ биелүүлээгүйн улмаас бирж тухайн гишүүн эсвэл түүний харилцагчийн зөвшөөрлийг үл харгалзан дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ. Үүнд:

8.6.1.1. Биржийн гишүүн, түүний харилцагчийн эзэмшиж буй гэрээний төлбөрийн үүрэгтэй холбогдсон аливаа гүйлгээг зогсоох;

8.6.1.2. Биржийн гишүүн, түүний харилцагчаас арилжааны захиалга хүлээн авахгүй байх, захиалга биелүүлэхээс татгалзах;

8.6.1.3. Биржийн гишүүний өөрийн болон бусад харилцагчийн нэрийн өмнөөс эзэмшиж буй гэрээг бусад биржийн гишүүнд шилжүүлэх;

8.6.1.4. Биржийн дэнчингийн данс, төлбөр тооцооны дансанд байршуулсан аливаа хөрөнгийг тухайн арилжаанд оролцогчийн Бирж, бусад арилжаанд оролцогч болон тэдгээрийн харилцагч, өөрийн харилцагчид учруулсан хохирлыг барагдуулахад ашиглах;

8.6.1.5. Биржийн гишүүний Бирж болон гэрээний нөгөө талд учруулсан хохирлыг арилгахад дэнчин, төлбөр тооцооны дансанд байршуулсан хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд тухайн Биржийн гишүүний эрсдэлийн санг ашиглана.

8.6.1.6. Биржийн гишүүний эрсдэлийн сангаас хөрөнгө гаргах тохиолдолд Эрсдэлийн сангийн журамд заасны дагуу зохицуулна.

8.6.1.7. Дэнчин, барьцаа хөрөнгө, эрсдэлийн санд байршуулсан хөрөнгө нь Биржийн гишүүний Бирж болон гэрээний нөгөө талд учруулсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад шилжүүлж, асуудлыг шийдвэрлүүлнэ.

8.7. Биржийн гишүүн нь арилжаанд оролцох, арилжаа клиринг, төлбөр тооцооны гүйцэтгэлтэй холбогдон гарсан аливаа санхүүгийн үүргээ биелүүлээгүйгээс Бирж болон гэрээний нөгөө талд хохирол учруулсан бол хохирлын хэмжээг тооцож, холбогдох арга хэмжээг авч, учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

8.8. Хэрэв Биржээс тухайн арилжаанд оролцогчийн хувьд гэрээний үүргээ биелүүлэхгүй байх нөхцөл байдал үүссэн гэж үзвэл тухайн үүргээ биелүүлэхгүй байх гэрээ буюу хэд хэдэн гэрээтэй холбогдсон аливаа гүйлгээг тухайн зөрчлийг арилгах хүртэл түр зогсоож болно.

8.9. Биржийн гишүүн, итгэмжлэгдсэн этгээд хууль, журам, гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд Биржийн гүйцэтгэх захирал Гишүүнчлэлийн журам, Итгэмжлэлийн журамд заасан хариуцлага ногдуулах эрхтэй.

8.10. Биржийн Гүйцэтгэх захирал дараах тохиолдолд биржийн гишүүний эрхийг хэсэгчлэн болон бүхэлд нь түдгэлзүүлнэ. Үүнд:

8.10.1. 2 удаа сануулах арга хэмжээ авсан ба зөрчлөө арилгаагүй бол;

8.10.2. Биржийн дүрэм журам, шийдвэрийг биелүүлээгүй бол;

8.10.3. Биржийн гишүүн нь харилцагчаас олгосон итгэмжлэлийн хүрээнд гүйцэтгэх үүргийг биелүүлээгүйгээс харилцагч болон Биржид хохирол учруулсан бол;

8.10.4. Биржийн гишүүний эд хөрөнгийг битүүмжилсэн тухай албан ёсны мэдээлэл эрх бүхий байгууллагаас биржид ирсэн бол;

8.10.5. Монгол улсын хуулийн дагуу биржийн гишүүнд дампуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж эхэлсэн бол;

8.10.6. Монгол улсын хуулийн дагуу биржийн гишүүн нь хуулийн этгээдийн зохион байгуулалтын өөрчлөлт хийж байгаа бол;

8.10.7. Биржийн гишүүний шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон бол;

8.10.8. Холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт хориглосон үйл ажиллагаа явуулсан болон Биржийн гишүүнтэй байгуулсан гэрээнд заасан бусад.

8.11. Биржийн Гүйцэтгэх захирал биржийн гишүүний эрхийг дараах тохиолдолд цуцална. Үүнд:

8.11.1. Биржээс эрхийг нь түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй бол;

8.11.2. Бирж нь хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тус баримт бичиг нь худал мэдээлэл агуулсан, хуурамчаар үйлдэгдсэн нь тогтоогдвол;

8.11.3. Биржийн гишүүн өөрөө хүсэлт гаргасан бол;

8.11.4. Хуулийн этгээд татан буугдаж Улсын бүртгэлээс хасагдсан бол;

8.11.5. Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон бол;

8.11.6. Холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт хориглосон үйл ажиллагаа явуулсан болон Биржийн гишүүнтэй байгуулсан гэрээнд заасан бусад.

8.12. Биржийн арилжаанд оролцогч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг дараах байдлаар тооцно. Үүнд:

- 8.12.1. Нийт эзэмшиж буй спот болон фьючерс гэрээг тодорхойлох;
- 8.12.2. Тодорхойлон гаргасан спот болон фьючерс гэрээнд харгалзах мөнгөн дүнг тооцох;
- 8.12.3. Мөнгөн дүнг тооцохдоо тухайн арилжаанд оролцогчийн гэрээний үүргээ биелүүлээгүй гэж зарлагдсан өдрийн төлбөр тооцоо хийх үнийг ашиглах.

8.13. Хяналт, шалгалтаар биржийн үйл ажиллагаанд биржийн оролцогч болон ажилтан нь хууль тогтоомж, журам, холбогдох гэрээ, хэлцлийг зөрчсөн нь тухай бүр засах боломжтой, ялимгүй зөрчил бол тухайн асуудал хариуцсан ажилтанд зөрчлийг арилгах талаар зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулна. Энэ талаар Гүйцэтгэх захиралд танилцуулж, биелэлтэд хяналт тавина.

8.14. Хяналт, шалгалтаар биржийн үйл ажиллагаанд биржийн оролцогч болон ажилтаны гаргасан зөрчлийг арилгуулах, хариуцлага ногдуулахад биржийн хууль, тогтоомж, дүрэм, журам, мөн харилцагчтай байгуулсан гэрээ, хэлцэлд хариуцлага хүлээлгэх зохицуулалтаар боломжит арга хэмжээг авна.

8.15. Зөрчлийн шинж байдлыг харгалзан хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх захиралд илэрсэн зөрчлийг танилцуулж, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх эсэх талаар санал боловсруулж, зохих заавар, зөвлөмжийн дагуу ажиллана.

8.16. Энэхүү журмын 3-6 дугаар зүйлд заасан хяналт, шалгалтыг гүйцэтгэх явцад зөрчил гаргасан үйлдэл илрүүлсэн тохиолдолд энэ журмын 1.4-д заасны эрх зүйн баримт бичгийн хүрээ, дарааллыг баримтлан арга хэмжээ авна.

8.17. Хяналтыг шаардлага хангах хэлбэрээр зохион байгуулж, төлөвшүүлж чадаагүй, үүнээс компани болон харилцагчид хохирол учирсан, учирч болзошгүй нөхцөл байдал үүсгэсэн бол Гүйцэтгэх захирал болон захирлын зөвлөлөөр, гэмт хэргийн шинжийг агуулсан бол хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх эсэх тухай саналаа боловсруулж, Гүйцэтгэх захиралд танилцуулснаар дараагийн арга хэмжээг авч ажиллана.

8.18. Зах зээлийн хэвийн бус нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор арилжаанд оролцогчид учирсан ямар нэгэн алдагдал, хохирлыг Бирж хариуцахгүй.

8.19. Итгэмжлэгдсэн этгээд нь арилжсан бараа, түүхий эдийн чанар стандартын талаарх мэдээллийг үнэн зөв оруулаагүйн улмаас үүсэх хохирлыг бирж хариуцахгүй.

8.20. Хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий этгээд нь хяналт, шалгалтыг зохих ёсоор гүйцэтгээгүй, нуун дарагдуулсан, эрх хэмжээгээ хэтрүүлсэн, хувийн ашиг сонирхлоор хандсан нь аливаа хэлбэрээр илэрсэн тохиолдолд компани болон харилцагчид хохирол учруулахуйц нөхцөл байдлыг бий болгосон, эсвэл учруулсан тохиолдолд гарсан хохирлыг барагдуулах, Хөдөлмөрийн дотоод журам болон Хөдөлмөрийн гэрээгээр зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэнэ.